

**МАХН, ӨВӨР МОНГОЛД АРДЫН
ХУВЬСГАЛТ НАМ ҮҮСЧ БЭХЖИХЭД
ТУСАЛСАН НЬ**

Л. Жамсран

Хятадад хувьсгалт нэгдмэл фронт нэгэнт байгуулагдан ажиллаж байсан нөхцөлд Барга, Дотоод Монголд мөн хувьсгалт байгууллагуудыг нэгтгэж нийт Өвөр Монголын үндэсний эрх чөлөөний тэмцлийг нэгдмэл удирдлагатай болгох бодит шаардлага үүсчээ.

Эл шаардлагыг хэрэгжүүлэх дотоод, гадаад нөхцөл тэр үед бүрэлдэж байв.

Фэн Юйсян, өмнөд Хятадын Гуандунгийн Засгийн газрын бодлогыг дэмжиж, ЗХУ, БНМАУ-тай харилцаж, тусламж авах болсон нь, түүний хяналтад байгаа нутагт зарим хэсэг нь багтдаг Өвөр Монголд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн далайцтай өрнөхөд таатай нөхцөл болов. Тэр үеийн Өвөр Монголын Барга, Дотоод Монгол, Ордос зэрэг нутагт тус тусдаа хувьсгалт байгууллага үүсэн ажиллаж байлаа. Тэдгээрийг зохион байгуулалтын талаар нэгтгэж, өрнөж байгаа олон түмний эрх чөлөөний тэмцлийг эрчимтэй удирдах явдал цаг үеийн шаардлага болж байв. Бид тэдгээр байгууллага анх хэрхэн үүсч, яаж нэгдсэнийг авч үзье.

Ар Монголын ард түмэн МАХН-ын удирдлагаар Оросын ялгуусан ард түмэнтэй ангийн холбоо тогтоож, Оросын цагаантан, хятадын зандалчдыг үлдэн зайлуулж төрийн тусгаар тогтнолоо олоод аливаа дарлал мөлжлөгийг эгнэгт устгах нийгэм эдийн засгийн хувьсгалт ардчилсан өөрчлөлт хийж эхэлсэн нь хятадын захиргаан дахь Барга, Дотоод Монголын эх оронч, хувьсгалч үзэлтэй сэхээтнүүд, хувьсгалт монгол улс, түүний Ардын Хувьсгалт Нам, Зөвлөлт Орос улс, Коминтернтэй холбоо тогтоож харьяат нутаг орноо хятадын цэргийн эрхтнүүдийн ноёрхолоос чөлөөлөхийн төлөө ард олноо зохион байгуулахад нөлөөлсөн юм. Баргын эх оронч сэхээтэн Буянгэрэл (Фу Минтай), Мэрсээ (Го Даофу) нарын зэрэг хувьсгалчид 1922 онд Ар Монголын нийслэл Хүрээнд ирж тус орны байдалтай танилцаад, МАХН-тай ажил хэргийн холбоо тогтоосон ажээ. Тэдний зарим нь тухайлбал, Мэрсээ Зөвлөлт Орос улсад бас очжээ.¹ Зөвлөлт Орос улс, Хувьсгалт Монгол Улсын бодит байдал, тэдгээрийн хооронд үүссэн шинэ харилцааг олон түмэнд сурталчлах талаар нэлээд ажил хийсэн ажээ. Мэрсээгийн бичсэн «Монголын асуудал» гэдэг товхимол, 1923 онд хятад хэлээр хэвлэгдэн гарсан. Зохиогч товхимолдоо Монголчууд Манж Чин улсын ноёрхолыг устгаж үндэсний тусгаар тогтнолоо сэргээхийн төлөө тэмцсэнийг түүхчлэн харуулахдаа, монголчууд тусгаар тогтнох бүрэн эрхтэйг олон талаар нотолж Ар Монголд хувьсгал ялсныг талархан дэмжихийн хамт Өвөр Монгол энэ замаар явах ёстойг дурьдаад монгол дэлхий дээр тусгаар тогтносон улсын байр суурь эзлэх ёстой гэдгийг харуулахад их анхаарсан байдаг. Мөнхүү зохиогч хувьсгалт Монгол улсын тэр үеийн бодит байдлыг харуулах зорилгоор мөн онд «Шинэ мандсан Монгол» гэдэг товхимолыг хятад хэлээр бичиж хэвлүүлсэн. Иймэрхүү ажил нь тэд өөрсдийн хувьсгалт байгууллагыг үүсгэх нэг

зүйлийн бэлтгэл болж байжээ. Тэгээд ч Хөлөнбуйрын Баргын залуу чуудын энэ төлөөлөгчид нутагтаа эгэж очоод 1922—1923 оны заагаар «Монголын залуучуудын Нам» гэдэг хувьсгалт нууц байгууллага байгуулсан байна.² Үүнийг зохион байгуулагчид нь Буянгэрэл, Мэрсээ нар байжээ. Тус байгууллагын дүрмийн төсөлд «Намын уг зорилт нь бүх монгол аймаг угсаагаа ганцаар (тусгаар тогтносон Л. Ж.) ардын улс төр байгуулан бүтээхийг түргэлнэ» гээд тус намын уг зорилтыг зөвшөөрөөд бас ёс дүрмийг дагаж нэгэнт тус намын үйлдэлд зүтгэгчдийг цөмөөр тус намын гишүүн болгоно гэж зааснаас үзэхэд энэ байгууллага үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцлийг тэргүүн зэргийн зорилт болгож байсан нь илэрхий.

Тэр үед үүний зэрэгцээгээр Барга, Дотоод Монголын олон чуулган, хошуу хувьсгалт монгол улстай нэгдэх саналаа илэрхийлэн албан ёсны төлөөлөгчдөө нийслэл Хүрээнд удаа дараа ирүүлж байлаа. Гэтэл тэр үед энэ хүсэл биелэх бололцоогүй байв. Учир нь Барга, Дотоод Монголын ихэнх нутаг нь империалист японы нөлөөний хүрээнд хамрагдаж байсан бөгөөд японы талыг барьсан зүүн хойт хятадын цэргийн эрхтэн Чжан Цзолингийн шууд захиргаанд байлаа. Бээжингийн засгийн газар Өвөр Монголчуудын эл хүсэлтийг зөвшөөрөх байтугай хувьсгалт монгол улсын тусгаар тогтнолыг цуцлаж хятадад эгүүлэн нэгтгэх түрэмгий бодлогыг бүх шугамаар явуулж байсан юм. Тэр үед Монгол улсыг устгаж Өвөр Монголтой нэгтгэх замаар «Их Монгол» улс байгуулах гэсэн үзэл монгол туургатны зарим этгээдэд байлаа. Иймд тэр үзлийг МАХН шийдвэртэй няцаахдаа Өвөр Монголын ард түмний хөдөлгөөнийг тийм чиглэлээр өрнүүлэх гэсэн явууллагыг шийдэмгий буруушааж байлаа.³ 1925 оны 9-р сард хуралдсан МАХН-ын IV их хурлаас намын мөрийн хөтөлбөрийн асуудлаар гаргасан тогтоолд: «Монгол үндэстний өөрсдийн дур саналыг үл харгалзан албадан нэгтгэнэ гэгч хүчин нь Алс Дорнод зүгийн олон улсууд ба ялангуяа Хятадын эрх чөлөөгөө олох үндэсний хувьсгалын зэрэг хэргүүдийг зохилдуулан нэгтгэх явдал хортой болохыг илэрхийлнэ»⁴ гэж заасан нь МАХН-ын цаашдын үйл ажиллагаанд хөтөлбөр болсон юм.

Монгол улс 1923 онд эхлээд Хайларт дараа нь Чуулалт хаалга, Тяньцзин зэрэг хотод өөрийн Харилцан тусалцах хоршооны салбарыг нээж ажиллуулсан нь зөвхөн худалдаа гүйлгээнд ашигтай болсон төдийгүй Барга, Дотоод Монгол, хятадын хувьсгалт, хөдөлгөөнийг МАХН-аас дэмжихэд дөхөм болж байв. Жишээ нь Хайлар дахь Монгол улсын хоршооны салбарыг түшиглэн. Барга өөрийн хувь нийлүүлсэн хоршоо байгуулж орон нутагтаа бас хэдэн салбар, дэлгүүр нээн ажиллуулж байв. Тэгэхэд тэр хоршоо болон түүний салбаруудын дэргэдэх Залуучуудын Нам ард олны дунд ЗХУ, Монгол улсын ололт амжилтыг сурталчлах, үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэх үзэл санааг дэлгэрүүлэхийн зэрэгцээгээр хувьсгалт боловсон хүчин бэлтгэхийн тул Монгол улсын нам ба цэргийн сургуульд залуучуудыг явуулан сургах ажил зохиож байв. Тухайлбал, 1924 онд 5, 1925 онд 44 хүнийг БНМАУ ын сургуулиудад явуулан суралцуулсан байна.⁵

1924 оны эхний хагаст хятадын ГМДН-ын төлөөлөгчөөр монгол улсад ирж МАХН-тай хэлэлцээ хийж байсан Сэрэндонров (Бай Юньти) Өвөр Монголын залуучуудын дунд ГМД намын үндэстний бодлого, мөн намаас МАХН-тай харилцаж байгаа байдал тэргүүтнийг өргөн сурталчилж 1924 оны сүүлчийн хагаст «Дотоод Монголын Улс Ардын (Гоминьдан) нам» гэгчийг Чуулалт хаалга хотод байгуулан ажиллаж эхэлсэн. Тэгэхэд Баргын Залуучуудын Нам түүнтэй хамтран ажиллах болов. Мөн тэр жил дотоод монголын Их Зуугийн чуулганы Ордосын

эрх чөлөөний хөдөлгөөний* нэрт зүтгэлтэн Ванданьямын санаачилгаар дугуйлангийн хөдөлгөөний удирдагч Өлзийжаргал тэргүүтэй төлөөлөгчид Улаанбаатарт хүрэлцэн ирж МАХН-ын Төв Хороотой харилцаа тогтоон үндэсний эрх чөлөөний тэмцэлдээ дэмжлэг олж монгол улсын нам ба цэргийн сургуульд Ордосын залуучуудыг суралцуулж эхэлсэн юм.⁶

Өвөр Монголын зохиогч Отгонбилэг «...Дотоод Монголын Ардын Хувьсгалт Нам» гэдэг өгүүлэлдээ дугуйлангийн хөдөлгөөний удирдагч Өлзийжаргал (Шинэ лам) харгис хүчинд хавчигдан 1920 онд Үүшин хошуунаас оргон гарч Бээжинд нуугдаж байгаад «1924 онд тэр эрс шуурхайгаар хошуунд харьж ирээд «дугуйлангаа» сэргээх гэсэн боловч, феодал ван гүнгийн нэхэмжлэн баривчлах ба дарангуйлах байдал дор тогтнох аргагүй болохоор «дугуйлангийн» 15 дайчин ханиа дагуулан БНМАУ-д судлан суралцахаар очив. Тэр хувьсгалын шуурган дундуур зогсолтгүй тэмүүлэн урагшилж хувьсгалын үнэн ёсыг эрж хайжээ. 10 сарын хувьсгал болон Халх Монголын ардын хувьсгал, Дундад Улсын Эв хамт намын удирдсан Дундад Улсын хувьсгал түүнд Монголыг чөлөөлөх замыг зааж өгөв»⁷ гэжээ. Өвөр Монголын нутгуудад ажиллаж буй эдгээр байгууллага нэг зорилготой байсан тул нэгдмэл хувьсгалт нэгэн байгууллага болж нэгдэх бололцоотой болсон. Иймээс 1924 оны өвөл дотоод монгол, баргын хувьсгалт байгууллагын төлөөлөгчид Бээжинд хуралдаж нэгэн намын хүрээнд нэгдэх асуудал хэлэлцжээ. Тэгээд тэд «Дотоод Монголын улс ардын нам» гэдэг нэрийг өөрчилж «Дотоод Монголын ардын хувьсгалт нам» хэмээн нэрийдэж түр цагийн төв хороо байгуулж түүний тэргүүлэгч гишүүнээр дотоод монголын Зост, Жирэм, Их зуугийн чуулган Хөлөнбуйр (Барга), Цахар зэрэг чуулган аймгийн эрх чөлөөний хөдөлгөөний нэрт зүтгэлтэн 9 хүнийг сонгосон байна.⁸ Түр цагийн төв хороо намынхаа их хурлыг ойрын хугацаанд зарлан хуралдуулах бэлтгэл ажилдаа тус дэмжлэг олохын тул Москва, Улаанбаатарт тус бүр төлөөлөгч томилон илгээсэн ажээ.⁹ Улаанбаатарт 1925 оны хавар ирсэн Сэрэндонров, Буянгэрэл нарын зэрэг бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид нь юуны урьд тэр үед Улаанбаатарт ирээд байсан Дорнод хязгаарын Хувьсгалт Ардын Намын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж хоёр байгууллагыг нэгтгэж нэгэн ерөнхий хороо байгуулахаар тохиролцсон байна. Дорнод хязгаарын Хувьсгалт Ардын Нам бол барга, өвөрмонголын хувьсгалчид 1924 оны сүүлчээр МАХН-ын шууд туслалцаатайгаар Залуучуудын Намаа өөрчлөн байгуулсан нь болой. Гэтэл Өвөр Монголын Отгонбилэг гэгч зохиогч 80-аад оны эхээр нийтлүүлсэн Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын тухай судалгааны дэлгэрэнгүй өгүүлэлдээ: Баргын хувьсгалчдын эхэн үеийн ажиллагаа ба МАХН-ын дэмжлэгийг зохих ёсоор дурдаагүйгээс гадна өвөр монголын хувьсгалчид «...Ли Дачжао болон Сүн Чжуншан (Сун Ятсен Л. Ж)-аар дамжуулан Эв хамтын интернационал (Коминтерн) хийгээд Бүгд Найрамдах Монгол улстай харилцав»¹⁰ гэж бичсэн нь БНМАУ-ын хувьд үнэн байдалд нийцэхгүй. Тэр үеийн Өвөр Монголын хувьсгалчид МАХН ба БНМАУ-тай шууд харилцаж дэмжлэг тусламж авч байсан юм. МАХН-ын Төв Хороо Өвөр Монголд хувьсгалч боловсон хүчин нэн их шаардлагатай байгааг харгалзан түүний түр цагийн төв хорооны хүсэлтээр Өвөр Монголын 50 хүнийг өөрийн зардлаар цэргийн сургуульд хурдавчлан сургаж өгөхөөс гадна 5 түмэн янчааны буцалтгүй тусламж өгөхөөр шийд-

* XIX зууны II хагаст анх үүссэн Ордосын дугуйлан бол тэр нутгийн ард олны эрх чөлөөний тэмцлийг удирддаг байгууллага юм.

вэрлэж эхний ээлжинд 2 түмийг олгожээ. Дотоод Монголын Ардын Хувьсгалт Нам (ДМАХН)-ын зарлан хуралдуулах гэж буй их хурлын бэлтгэл ажилд аль болохоор туслахаас гадна мөнхүү төлөөлөгчдөд «Фэн Юйсян ба Гоминьдан нам лугаа эв найртай явалцаж Дундад улсын хувьсгалын явдалд хамтаар оролцон явж Коминтерн лугаа бас холбоотой болох хэрэгтэй¹¹ гэж зөвлөсөн нь шинэ тутам байгуулагдаж буй тус нам тактик, стратегиа боловсруулахад тус болсон нь мэдээж.

ДМАХН-ын түр цагийн төв хороо Өвөр Монголын ард түмэнд өөрийн зорилгыг танилцуулах, тус орныг эрсдүүлж байгаа дарлал, мөлжлөгийн мөн чанар, нийгмийн ба үндэсний дарлал Зөвлөлт Орос улс, БНМАУ-ын бодит байдал, Өвөр Монголын ард түмэн эрх чөлөөгөө олох арга зам тэргүүтнийг сурталчлах зорилгоор хэвлэлийн хороо байгуулж, 1925 оны 3 сард Өвөр зургаан чуулган хийгээд баргын зэрэг газар гишүүдийг томилон явуулж хэд хэдэн зүйлийн ухуулах хуудас, тунхаг бичиг нийтэлж зарласнаас гадна чуулгануудад намын хороо байгуулжээ. Намын анхан шатны байгууллага байгуулахын зэрэгцээгээр «Монгол угсаагаа дэлгэрүүлэн мандуулах хурал» гэдгийг байгуулж империализмын дарлалаас ангижирч, ард нийтээрээ эрх тэгш болохын төлөө тэмцэгч лам, хар, эрэгтэй, эмэгтэй хэнийг боловч элсүүлэх болсон ажээ. Түүний дүнд 1925 оны 7-р сарын байдлаар ДМАХН нь 300 гаруй жинхэнэ гишүүнтэй 3000 гаруй орлогчтой, Монгол угсаагаа дэлгэрүүлэн мандуулах хурал нь 10-аад мянга шахам гишүүдтэй болсон байв.¹²

БНМАУ-д ирсэн төлөөлөгчдөө буцаж очсоны дараа ДМАХН-ын түр цагийн Төв Хорооны тэргүүлэгч гишүүдийн хурал 7-р сарын 26-нд хуралдаж Төв Хороог Чуулалт хаалга руу нүүлгэх ДМАХН-ын анхдугаар их хурлыг зарлан хуралдуулах, олон чуулган хошууны намын үүр хороодоос их хуралд оролцох төлөөлөгчдийн тоо, сонгох журам их хурлаар батлах баримт бичгүүдийг боловсруулах зэрэг асуудал хэлэлцэж зохих шийдвэрүүд гаргасан.

ДМАХН-ын Түр цагийн ТХ их хурлынхаа бэлтгэл ажлыг ийнхүү шуурхай хийхдээ намын эгнээг өргөтгөх, журамт цэрэг байгуулах, хятадын цэргийн эрхтэнүүдтэй сүлбэлдэн ард олныг дарлан зовоож байгаа орон нутгийн феодалуудыг эсэргүүцэх талаар идэвхтэй ажил зохиосон нь бүх Өвөр Монголын намын байгууллагын төлөөлөгчдийн их хурлыг зарлан хуралдуулах боломжтой болгов.

Иймээс 1925 оны 10 сард Чуулалт хаалга хотод намын төлөөлөгчдийн их хурал хуралдаж Өвөр Монголын олон чуулган, хошуудын байдлын тухай илтгэлүүдийг хэлэлцээд үндэсний эрх чөлөөгөө олохын төлөө тэмцэлд эрхбиш өөрийн хувьсгалт нам байгуулбал зохино. Энэ хүү нам нь бүх дарлагдсан ардыг удирдаж, дотоод гадаадын харгисуудаас эрх чөлөөг олохын тул тэмцэх болно»¹³ гэж үзээд Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намыг (ДМАХН) албан ёсоор байгуулахаар шийдвэрлэсэн байна. Түүнчлэн тус намын мөрийн хөтөлбөр ба их хурлын тухай тунхагийг батлахын хамт намын удирдах төв байгууллагыг сонгов. Тус төлөөлөгчдийн их хуралд дотоод монголын 6 чуулган, Цахар, Барга, Дагуур, Хөлөнбуйр, Алаша, Эзний гол, Хөх нуур зэрэг Өвөр Монголын бүх нутгаас сонгогдсон 100 шахам төлөөлөгчдөөс гадна Коминтерн, МАХН ба Хятадын коммунист намын төлөөлөгчид зочноор оролцсон юм. Тэрчлэн хятадын ГМДН ба Фэн Юйсяний цэргийн төлөөлөгчид болон орон нутгийн зарим эрх баригчид их хуралд суусан ажээ. Их хурлаас баталсан мөрийн хөтөлбөрт намын үндсэн зорилтыг заахдаа: 1. Олон ардын одоогийн зовлонт байдлыг арилгах явдалд амь биеийг хайрлахгүйгээр зүтгэх. 2. Ардын эрхт

засгийг байгуулах олон ардын ашиг тусыг хамгаалан бадруулах. 3. Олон монгол үндэс, угсаагаа нэгэн хэлхээгээр хөгжүүлж энэ цагийн эрдэм соёлын гэгээн боловсролд удирдах. 4. Дундат Улсын ардын ангиудтай хүчин хавсарч харгис цэргийн эрхтэн ба эзэрхэг түрэмгий явдлыг устгах зэрэг зүйл болно»¹⁴ гэжээ.

Их хурал ДМАХН-ын ТХ-г 45 хүний бүрэлдэхүүнтэй сонгож Төв Хорооны тэргүүлэгчээр Сэрэндонров, нарийн бичгийн даргаар Мэрсээ, гүйцэтгэх (тэргүүлэгч) гишүүн 8 хүн сонгогдсоны дотор Буянгэрэл, Муранга (Яо Цзинтао) нарын зэрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэрт зүтгэлтэн хувьсгалчид оролцсон байна.

Их хурал намын үзэл суртлыг ард түмний дотор сурталчлахын тул «Дотоод Монголын ардын сэтгүүл» *-ийг монгол хэлээр тогтмол хэвлэн гаргаж байхаар шийдэв.

Их хурал бас «ДМАХН-ын анхдугаар их хурлаас олон түмэн ард нийтэд тунхаглан зарлах бичиг» батлан гаргав. Түүнд хятад улсад тунхагласан таван угсаатны тэгш эрх байхгүй. Харин цэргийн эрхтнүүд империалистуудтай сүлбэлдэн ард түмнийг зүйл бүрээр зовоон тарчилгаж байгаа тул өвөр монголчууд эрх чөлөөнийхөө төлөө тэмцэх хэрэгтэйн чухлыг онцлон заахын хамт» Гагцхүү Зөвлөлийн Засагт Холбоот Улс ба Ардын Хувьсгалт Гадаад Монгол бөгөөс (бол Л. Ж.) дарлагдсан бага буурай улсын нөхөр хань болж байна» гэж цохон тэмдэглэсэн байна.¹⁵ Мөнхүү тунхаглан зарлах бичигт «намаас тогтоон гаргаж хүчлэн гүйцэтгэх зүйл нь:

1. Дундат Улсад багтсан олон угсаатнууд тус тусын аймаг угсааны хэргээ өөр өөрөө эзэрхэн таслах (өөрөө засан тохинох Л. Ж.) эрхтэй болгохыг эрмэлзэнэ.

2. Дундат Улсын ард түмэн гадаадын эзэрхэг түрэмгий ба дотоодын шунахай харгисуудаа устгаж чухамхүү ардын эрхтэй засаг байгуулахын үед бидний дотоод монголчууд мөн ч ардын эрхтэй хувьсгалт засаг байгуулахыг гүйцэтгэнэ.

3. Олон түмэн ард эр эм хэн ч атугай эрх тэгшээр цөм улс төрийн хэрэгт боловсрон, удирдан оролдон гүйцэтгэнэ» гэж зааснаас гадна харгис этгээдийн орон нутгийн захиргааны эрхийг устгаж ардчилсан сонгуулиар орон нутгийн захиргаа байгуулах, бүх Өвөр Монголын ардын төлөөлөгчдийн хурлыг хуралдуулахыг» даруй гүйцэтгэх зорилт болгон тавьжээ. Түүнчлэн эдийн засаг, соёл, боловсрол ба шашин мөргөлийн талаар ДМАХН-аас явуулах бодлогын үндсэн чиглэлийг хэд хэдэн зүйлээр тодорхойлсон байна.

Олон улсын коммунист хөдөлгөөний шууд дэмжлэгээр хуралдсан тус их хурал нийт Өвөр Монголын эрх чөлөөний тэмцлийг удирдан зохион байгуулах улс төрийн ганц нам ДМАХН-ыг жинхэнэ байгуулж хятадад үүсээд байгаа хувьсгалт нэгдмэл фронтын хүрээнд империализм, феодализмыг эсэргүүцэн эрх чөлөөний төлөө тэмцэх үндсэн чигийг зааж өгсөнд түүний гол ач холбогдол оршино. Тус намын шинж чанарыг Өвөр Монголын судлаач Отгонбилэг дээр дурдсан өгүүлэлдээ тодорхойлохдоо: «Дотоод Монголын Ардын Хувьсгалт Нам бол үндсэндээ үгээгүү анги болон Монгол үндэстний хөдөлмөрчин Малчин тариачин холбоолсон хэлбэртэй Хувьсгалт төрийн (улс төрийн Л. Ж.) нам мөн»¹⁶ гэжээ. Шинэ байгуулагдсан ДМАХН нь Үндэсний нэгдсэн фронтын байгууллага шинжтэй тул бүрэлдэхүүний хувьд жигд

* ДМАХН-ыг байгуулах бэлтгэл ажилд идэвхтэй оролцсон БНМАУ-ын зохиолч, нам, олон нийтийн зүтгэлтэн С.Буяннэмэх 1925— 1926 онд Цэцэнбилэг гэдэг нэрээр тус сэтгүүлийн анхны эрхлэгчээр ажиллаж байсан юм.

биш байлаа. Улаанхүү, Заяатай нарын зэрэг ХКН-ын гишүүд, Сэрэндонров тэргүүтэй ГМД намын гишүүд, Буянгэрэл, Мэрсээ нарын зэрэг сэхээтний хувьсгалч төлөөлөгчид, Ванданням нарын зэрэг үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгчид, Дэмчигдонров зэрэг үндсэрхэг үзэлтэй феодал гэх мэт нийгмийн янз бүрийн анги давхаргааны төлөөлөгчдөөс бүрдэл болж байлаа. Тус намыг төрүүлсэн нийгмийн бааз ч бас л жигд байгаагүй нь мэдээж. Энэ нь харийн колоничлолыг устгаж үндэсний эрх чөлөөгөө олох явдал тэр үеийн Өвөр Монголын хувьсгалт тэмцлийн эн тэргүүний зорилт болж байсан болохоор тэр тэмцэлд эх оронч бүх хүчийг нэгтгэн нягтруулах нь тухайн үеийн гол хандлага байснаар юуны урьд тайлбарлагдана. Тэгэхдээ ард ангийн сонирхлыг онцлон анхаарч байсан нь бидний дээр иш татсан баримт бичгээс илэрхий байна. Их хурлаас сонгосон Намын Төв Хорооны удирдлагад ГМД намын гишүүд, тэднийг талархагчид зонхилсон нь тус намын цаашдын ажиллагаанд нөлөөлөх нь дамжиггүй байв.

Өвөр Монголын ард түмэн ДМАХН байгуулагдсан явдалд баярлан талархаж түүний эгнээнд дуртай элсч, орон нутагт намын үүр, анхан шатны хороо олон газар байгуулагдаж байв. Түүнчлэн хувьсгалт залуучуудын эвлэлийн байгууллага үүсч байв. ДМАХН-ын ТХ 1925 онд тэргүүлэгч гишүүн Мурангаагийн удирдлагаар Дотоод Монголын Ардын цэргийг байгуулав. Орон нутагт ардууд харгис ван, гүн хийгээд хятад колоничлогчид, цэргийн эрхтнийг эсэргүүцэх журамт цэрэг байгуулан тэмцэж байлаа. Үүний дүнд зарим хошуу нутагт ДМАХН хяналтаа тогтоож байх болов. Тухайлбал Их зуугийн чуулганы, Отог, Үшин зэрэг хошуунд 1925 оны сүүлчээр ДМАХН-ын байгууллага хяналтаа тогтоож хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах тухай хошууны тамгын газартай гэрээ байгуулан¹⁷ цэрэг байгуулжээ. Зөвхөн Үүшин хошуунд ДМАХН-ын ТХ-ны гишүүн, дугуйлангийн удирдагч Өлзийжаргалын мэдэлд 700 гаруй цэрэг байлаа. Гэтэл цэрэгт зэвсэг хүрэлцэхгүй байв. Тэр 700 цэргийн дөнгөж 140-өөд нь буутай бусад нь буугүй байжээ.¹⁸ Газар бүр энэ мэтээр зэвсэг дутагдах төдийгүй цэрэг удирдах боловсон хүчин нэн хангалтгүй байлаа.

Иймээс ДМАХН-ын ТХ нь ЗХУ-ын цэргийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар өмнө Хятадад Сунь Ятсений засгийн газрын байгуулсан Хуанпугийн цэргийн сургууль, Чуулалт хаалганд Фэн Юйсяний байгуулсан цэргийн сургуульд цөөн хүн сургахын зэрэгцээгээр мөнхүү хотод 1925 онд Намын төв сургууль байгуулж хувьсгалт боловсон хүчин бэлтгэж эхэлсэн юм. Гэвч энэ нь тухайн үеийн хэрэгцээг хангаж чадахгүй байв.

Иймд ДМАХН-ын зэр зэвсгийн сургагчаар туслахыг ЗХУ ба БНМАУ-д хүссэн билээ. Зөвлөлт засгийн газар ДМАХН-д боловсон хүчин бэлтгэж өгөхөөс гадна энэ хүсэлтийн дагуу 1926 онд 1 сая сум бүхий 1 мянган винтов, 50 мянган сумтай 5 хүнд пулемёт 500 гранат болон цэргийн сургагчид ирүүлэн тусалсан юм.¹⁹ БНМАУ Фэн Юйсяний цэрэгт ЗХУ-аас нийлүүлэх зэвсэг техникийг өөрийн нутгаар гаальгүй нэвтрүүлэх, тээвэрлэн хүргэх, агт нийлүүлэх болон бусад материаллаг тусламж өгөхдөө Барга, Дотоод Монгол зэрэг хятад бус угсаатанд өөртөө засах эрх олгуулах болзол тавьж байлаа.²⁰ Хятадын хувьсгалд туслах зорилгоор 1925 оны 11-р сард Улаанбаатар-Чуулалт хаалга, Улаанбаатар-Дээд Үдийн хооронд автомашины байнгын тээврийн ажиллагааг нээсэн билээ.²¹ БНМАУ 1926 онд Өвөр Монголоос 200 шахам залуучуудыг нам ба цэргийн сургуульдаа өөрийн зардлаар сургаж өгөхөөр хүлээн авав.²² Тэрчлэн мөн онд ДМАЦ-т 50 сэлэм, 200 винтов, 1 их бууг зохих тооны сумны хамт өгч тусалснаас гадна Бар-

гад цэргийн зөвлөгч 1, сургагч 2, Дотоод Монголд зөвлөгч 1, сурагч 4-ийг тус тус томилон явуулж ажиллуулсан юм.²³ ЗХУ, БНМАУ-ын энэ мэтийн тусламж бол зөвхөн Өвөр Монголд төдийгүй чухамдаа нийт хятадын үндэсний хувьсгалд үзүүлсэн пролетарийн интернационалч тусламжийн нэг хэсэг юм. Дэлхийн хамгийн олон хүн амтай Хятад оронд явагдаж буй ардчилсан хувьсгалт тэмцлийг аль болохоор түргэн ялуулах нь ангийн дарлал, мөлжлөггүй шинэ нийгэм байгуулахын төлөө тэмцэж буй ууган хоёр орон, тэдгээрийн удирдан жолоодогч намуудад юу юунаас чухал байлаа.

1. «Дотоод Монголын ардын сэтгүүл». Чуулалт хаалга, 1925 он No 2, 11-р тал,
2. Жачисэчин. Мэнгу чжи цзиньси (Монголын урьд одоо) Тайбэй, 1955, 255-р талд
3. Д. Даш. 1925-1927 оны Хятадын хувьсгал, МАХН-ын интернационалч бодлого «МАХН-ын түүхийн асуудал» №12, УБ., 1977, 151-р талд
4. «МАХН-ын их бага, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр » 1 боть, УБ., 1956, 145-р тал
5. Жачисэчин, 251-р тал
6. НТТА. ф--- 1, т— 34, ХН— 20
7. «Монголын түүхийн тухай өгүүллүүд» Хөх хот, 1981, 327-328-р тал.
8. НТТА. ф-1, т— 34, ХН— 18
9. «Известия Улан-Батор хото» 1925. 11 — 18
10. «Монголын түүхийн тухай өгүүллүүд» Хөх хот, 1981, 326-р талд
11. НТТА. ф-1, Т-34, ХН - 26
12. МАХН-ын IV их хурал. УБ., 1978, 50-51-р тал
13. «ДМАХН-ын анхдугаар их хурлаас олон түмэн ардад тунхаглан зарлах бичиг» Чуулалт хаалга., 1925, 13-р тал
14. «Дотоод Монголын ардын сэтгүүл» Чуулалт хаалга. 1925 он, N 2, 8-9-р талд
15. «...тунхаглан зарлах бичиг 6-р талд
16. «Монгол түүхийн тухай өгүүллүүд» 341-рт
17. НТТА. ф-- 1, т. 34, ХН— 20
18. Мөн тэнд, ХН— 22
19. «Военная помощь СССР в освободительной борьбе Китайской народа» М., 1975. стр 28.
20. НТА. ф-1, т. 2, ХН—139
21. Известия Улан-Батор хото» 28-XI - 1925
22. «ДМАС» 1926 No 5, 35-р талд
23. НТТА. ф--1, т. 34, ХН—22